

ХАНБОГД СУМЫН МАЛЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ БОЛОН ОЮУ ТОЛГОЙ КОМПАНИЙН ХЭЛЦЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Ханбогд сум

Оюу толгой уурхай

2014 оны 11-р сарын 03-04-ний өдөр

Та бүхэнд САО-н оролцоотой маргааныг шийдвэрлэх Малчдын төлөөлөгчид болон Оюу Толгой ХХК-ийн хамтарсан уулзалтаар тохирсон асуудлын тухай мэдээлдэг билээ. Энэ удаад 11-р сарын 3-наас 4-ний өдрүүдэд хийгдсэн уулзалтын тойм мэдээг хүргүүлж байна. Уулзалтыг уламжлалт ёсоор Олон улсын санхүүгийн корпорацийн омбудсмэн (САО)-ий газрын зуучлагч чиглүүлж, Оюу Толгой Хяналт ТТБ малчдын зөвлөхөөр оролцов.

Энэ удаагийн уулзалт Оюу Толгой уурхайн талбайд хоёр өдөр үргэлжилсэн ба эхний өдөр Малчидын төлөөлөгчид уурхайн үйл ажиллагаатай танилцаж дараах байгууламжуудыг үзлээ.

- Ил уурхай
- Баяжуулах үйлдвэр
- Дулааны станц
- Ус цэвэршүүлэх байгууламж
- Хаягдал хадгалах байгууламж

Малчидын төлөөлөгчид мөн уурхайн удирдлагын багийн гишүүдтэй уулзаж уурхайн талбайгаар явахад ажиглагдсан болон бусад сонирхсон зүйлсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч зарим зүйлд харилцан тохирлоо Үүнд:

- Халив Дугатын голын голидрол өөрчилсөнтэй холбоотой асуудлыг 2014 оны 12-р сарын 15-16-ны өдрийн хамтарсан уулзалтаар хэлэлцэх, үүнтэй холбоотой мэдээллийг ОТ ХХК-с урьдчилан МТ танилцуулах
- Тоосны улмаас Малын эрүүл мэндийн асуудал үүсгэж байгаа тухай судалгаа хийсэн байгууллагатай МТ-ийг уулзуулах ажлыг ОТ зохион байгуулахаар тохиролцлоо.

Хоёр дахь өдрийн уулзалтаар өмнө хийхээр тохирсон ажлуудын хэрэгжилтийн явцыг хянан ОТ-с 20 км радиуст байгаа малчдад өвөл ус нийлүүлэх хувилбар хэлэлцэж, үүнтэй холбоотой талуудын хүлээх үүрэг хариуцлагын талаар хэлэлцлээ. Түүнчлэн ОТ-н Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан багтай уулзаж усны худгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, тендерийн үйл явцын талаар мэдээлэл сонслоо. Мөн Олон Талт Мэргэжлийн Шинжээчийн Баг (ОТМШБ) ажиллуулах тухай хэлэлцэж ажлын удирдамжийг эцэслэн сонгон шалгаруулах үйл явцыг зарчмын хувьд харилцан тохиров. ОТ ХХК-с ХБ суманд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авлаа. Гомдолд тусгагдсан ажлын байртай холбоотой асуудлыг 2015 оны 1-р сарын хамтарсан уулзалтаар хэлэлцэхээр тохиролцов. ОТМШБ-ийн Эрх зүйн хяналт, зөвлөгөө, омбудсмэн (САО)-ий газарт талууд орон нутгийн удирдлага, малчдын төлөөлөгчид, ОТ ХХК, ТББ, бусад оролцогч талуудыг оролцуулсан байнгын хамтарсан уулзалтын механизмтэй болоход зуучлаж өгөх хүсэлт гаргалаа.

Ханбогд сумын Малчдын төлөөлөгчид

Оюу Толгой ХХК